



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 25 өдөр

Дугаар

1339

Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

МУБИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлийг чанаржуулах, журамд нэмэлт өөрчлөлт оруулах зорилгоор МУБИС-ийн дүрмийн 4.4.1 дүгээр заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "МУБИС-ийн "Лавай" болон бүрэлдэхүүний сургуулиас эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах журам"-ын есдүгээр зүйлийг шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУБИС-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/255 дугаар тушаалаар батлагдсан "МУБИС-ийн "Лавай" болон бүрэлдэхүүний сургуулиас эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах журам"-ын 9 дэх зүйлийг хүчингүйд тооцсугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, инновацын албаны дарга (Я.Шийлэгмаа)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ О.АЛТАНГОО



20222566

**МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм
шинжилгээний сэтгүүлийг үнэлэх аргачлал**

Зорилго. ШУА-ийн салбарын бага чуулган, төрөлжсөн академиудаас эрхлэн буй эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг хөгжүүлэх талаар гаргасан зөвлөмж болон МУБИС-ийн “Лавай” болон бүрэлдэхүүний сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүлийн талаар баримталж буй бодлого, журмын хэрэгжилтийн хүрээнд сэтгүүлүүдийг үнэлэхэд энэхүү аргачлалыг хэрэглэнэ.

1. Нэр томьёоны тодорхойлолт. Энэхүү аргачлалд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

- 1.1. p-ISSN – www.issn.org байгууллагаас олгогдсон олон улсын цуврал(тогтмол) хэвлэлийн стандарт дугаар – хэвлэмэл бүтээл
- 1.2. e-ISSN – www.issn.org байгууллагаас олгогдсон олон улсын цуврал(тогтмол) хэвлэлийн стандарт дугаар – цахим бүтээл
- 1.3. DOI - (DOI-Digital Object Identifier)-Дижитал объект дугаар (www.crossref.org интернэт хуудсанд бүртгэгдсэн хэвлэгдсэн бүтээлийн цахим хаяг)
- 1.4. ORCID - (Open Researcher and Contributor ID)-Судлаач, оролцогч нарын нээлттэй дугаар (www.orchid.org хаягаар бүртгүүлсэн судлаачдыг бүртгэдэг цахим дугаар)
- 1.5. JPPS - (Journal Publishing Practices and Standards) framework-Сэтгүүл хэвлүүлэх практик, стандартуудын хамрах хүрээ (Хөгжиж буй орнуудын эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарыг сайжруулах зорилготой стандарт хөтөлбөр)
- 1.6. DOAJ –(Directory of Open Access Journals)- Эрдэм шинжилгээний нээлттэй сэтгүүлүүдийн лавлах
- 1.7. Scopus – Elsevier компанийн олон улсын мэргэжлийн сэтгүүлийн SJR, CiteScore зэрэг үнэлгээ тооцдог мэдээллийн сан
- 1.8. Web of Science - Clarivate Analytics компанийн олон улсын мэргэжлийн сэтгүүлийн импакт фактор үнэлгээ тооцдог мэдээллийн сан

2. Эрдэм шинжилгээний сэтгүүлийг үнэлэх зөвлөл нь бүрэлдэхүүн сургууль бүрээс сонгогдсон эрдмийн зэрэгтэй 2 багш, эрдэм шинжилгээ, инновацын албаны даргын бүрэлдэхүүнтэй байна.

3. Эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

Эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлт

	Шалгуур, үзүүлэлт	Оноо (0-2)	Тайлбар
1.Нийтлэлийн бодлого			
1.1	Сэтгүүл нь хэвлэн нийтлэлийн бодлоготой, түүнийг өгүүлэл бичих журам болон сэтгүүлийн интернэт хуудсанд тусгасан эсэх		
1.2	Сэтгүүлийн редакцын гишүүд, зохиогч, шүүмжлэгч нарын ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх зохицуулалтыг тусгасан эсэх		
1.3	Сэтгүүлийн өгүүлэл нь МУБИС-ийн оюуны өмчийн журмын дагуу хамгаалагдсан эсэх, үүнийг журамдаа тусгасан эсэх		
1.4	Сэтгүүлд хэвлэгддэг өгүүллүүд нь зохиогчийн эрхийн хамгаалалттай эсэх		
1.5	Сэтгүүлд өгүүлэл хүлээн авах шаардлагыг олон улсын түвшинд нийцүүлж боловсруулсан эсэх		
2.Редакцын зөвлөл			
2.1	Редакцын гишүүдийг салбарын гадаад, дотоодын тэргүүлэх зэргийн профессор, судлаачдаар бүрдүүлсэн эсэх		
2.2	Редакцын гишүүдэд зохиулсан шүүмж хийх алхамчилсан зураглалтай эсэх		
2.3	Редакцын гишүүд нь өгүүлэлд шүүмж өгдөг эсэх		
2.4	Редакцын гишүүд нь өгүүлэл хэвлэх шийдвэр гаргахад санал өгч оролцдог эсэх		
2.5	Редакцын зөвлөл нь ажлын байр, санхүүжилттэй эсэх		
3.Бүтээлийн агуулга			
3.1	Өгүүлэл нь тухайн сэтгүүлийн өгүүлэл бичих заавар болон олон улсын өгүүлэл бичих бүтцийн дагуу бичигдсэн эсэх		
3.2	Өгүүллийн хэмжээ, гарчиг болон агуулга тохирч байгаа эсэх		
3.3	Тухайн салбар шинжлэх ухаанд шинэ санаа дэвшүүлж, судалгааны үр дүнг баталсан эсэх		
3.4	Өгүүллийн найруулга нь монгол хэл дээр шинжлэх ухааны түвшинд бичигдсэн эсэх		
3.5	Англиар бичигдсэн хураангуй нь өгүүллийн агуулгыг бүрэн илэрхийлсэн, алдаагүй бичигдсэн эсэх		

4.Бүтээлийн бичвэр, формат			
4.1	Өгүүллийн нүүр хэсгийн загварыг олон улсын стандартын дагуу бичсэн эсэх		
4.2	Эшлэл, график, хүснэгт, ном зүйг APA стандартын дагуу бичсэн эсэх		
4.3	Зургийн чанар хэвлэлийн стандартыг хангасан эсэх		
4.4	Өгүүлэлд ашигласан ном зүйгээс зааврын дагуу бүрэн эш татсан эсэх		
4.5	Бүтээлийн гарчиг, хураангуй, байгууллагын хаягийг англи хэл дээр бичсэн эсэх		
5.Хянан магадалгаа			
5.1	Хянан магадалгаа хийх тогтолцоотой эсэх		
5.2	Хянан магадалгаа хийж буй шүүмжлэгч нарт зориулсан зөвлөмжтэй эсэх		
5.3	Бүтээлийн хуулбарлалтыг илрүүлдэг программ ашигладаг эсэх		
5.4	Бүтээлд хөндлөнгийн хянан магадалгааг 2-оос дээш шүүмжлэгчээр уншуулан хийлгэдэг эсэх		
5.5	Хянан магадалгаа хийх шүүмжлэгчдийн урамшууллыг сэтгүүлийн журамд тусгасан эсэх		
6. Сэтгүүлийн хэвлэл			
6.1	Сэтгүүл цахим хувилбартай эсэх		
6.2	Сэтгүүл дэх өгүүллийг төлбөртэй хэвлэдэг эсэх, журам болон өгүүлэл бичих зааварт тусгасан эсэх		
6.3	Сэтгүүлд 10 хүртэлх өгүүлэл хэвлэгддэг эсэх		
6.4	Сэтгүүл нь цаглаврын дагуу хугацаандаа тогтмол хэвлэгддэг эсэх (1-3 удаа)		
6.5	Сэтгүүлд өгүүлэл хүлээн авах алхамчилсан тайлбартай эсэх		
7. Сэтгүүлийн индексжүүлэлт			
7.1	p-ISSN-тэй		
7.2	e-ISSN-тай эсэх		
7.3	DOI дугаартай эсэх		
7.4	Зохиогчдын ORCID дугаарыг өгүүллийн эхэнд тавьсан эсэх		
7.5	Олон улсын салбарын хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлийн систем, сэтгүүлийн үнэлгээний платформуудад бүртгэгдсэн эсэх - Scholar.google.com - DOAJ		

	- Scopus - Web of Science		
8. Зохиогчийн эрх ба ёс зүй			
8.1	Зохиогч албан мэдээллийг өгүүллийн нүүр хуудсанд бичсэн эсэх /цахим хаяг, албан хаяг, холбоо барих утас/		
8.2	Зохиогчийн өгүүллийн оюуны өмчийн эрх хэнд, хаана хадгалагдахыг өгүүллийн нүүр хуудсанд тусгасан эсэх		
8.3	Оюуны өмчийн эрхийн зөрчлийг олон улсын хэм, хэмжээг мөрдөж шийдвэрлэдэг эсэх		
8.4	Судалгаанд ургамал, амьтан, хүний мэдээллийг ашиглахдаа ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдсөн эсэх		
8.5	Зохиогчийн эрх, үүргийг нийтлэлийн бодлогод тусгасан эсэх		
	Нийт		

4. Эрдэм шинжилгээний сэтгүүлийн чанарыг үнэлэх шалгуурыг 2, 1, 0 гэсэн оноогоор үнэлэх ба хамгийн ихдээ нийт 80 оноог авах ба үсгэн үнэлгээгээр илэрхийлбэл:

Хангалттай сайн	65-80
Хангалттай	50-64
Хангалтгүй	1-49